

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАЛАНЗАДГАД ГОВИЙН ИРЭЭДҮЙ” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2021/98-ШТА-ГА

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот 2021 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Ю.Энхтуяа

Утас: 70533552 Цахим хаяг: Enkhtuyayu@audit.gov.mn

Аудитор Э.Жаргал

Утас: 70533552 Цахим хаяг: Jargale@audit.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор	Товчилсон үгийн тайлбар	2
	Хүснэгт, график, зургийн жагсаалт	3
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4-5
С. Цэрэнбаяр	Бүлэг 1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна	6-12
Аудитын менежер:	- Бизнес төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан байна	6-8
Т.Хонгорзул	- Санхүүгийн зохистой байдал алдагдаж өр, авлага үүссэн байна	9-13
Аудитор:	Бүлэг 2. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа хангагдаагүй байна	13-22
Ю. Энхтуяа	- Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ашиглалт хангалтгүй байна	13-14
Т. Хишигбат	- Тоглоом, тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүй ашигласан байна	14-15
Э. Жаргал	- Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт хийгдээгүй байна.	15-16
2021 оны 10 дугаар сар	- Зарим тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна	16-17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.	- Хөрөнгө оруулалт үр ашиггүй байна.	18-22
	Санал	23
	Дүгнэлт	24
	Зөвлөмж	25
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Холбогдох байгууллагын санал	26
	Саналд өгсөн тайлбар	27
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот	Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	28-29
	Хавсралт № 1-2	30-31
	Тэргүүлэх аудиторын тушаал	32

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ӨБЦТС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
САХ	Соёл амралтын хүрээлэн
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгт 1	2018-2020 онуудын нийт зардлын эдийн засгийн ангилал
Хүснэгт 2	Авлагын судалгаа
Хүснэгт 3	Соёл амралтын хүрээлэнгийн хөрөнгийн жагсаалт
Хүснэгт 4	Худалдан авах ажиллагааны судалгаа
График 1	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар
График 2	Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал
График 3	Зардлын 2020 оны задаргаа
График 4	Өглөгийн судалгаа

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1	Дүрмийг шинэчлэн баталсан байдал
Дүрслэл 2	Үндсэн үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлтүүд
Дүрслэл 3	Бүтэц орон тооны өөрчлөлтүүд
Дүрслэл 4	Санхүүгийн тайланд хийсэн 2018-2020 оны аудитын дүгнэлтүүд
Дүрслэл 5	Соёл амралтын хүрээлэнд 2018 – 2020 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалт

Зургийн жагсаалт

Зураг 1	Гүн өрмийн худаг гаргасан байдал
Зураг 2	Гал тогооны тоног төхөөрөмж ашиглагдахгүй байгаа байдал
Зураг 3	Тамхины цэгт шороо орсон, дээврээс ус нэвтэрсэн байдал
Зураг 4	Усан завь зөрүүтэй нийлүүлэгдсэн байдал
Зураг 5	Гулсуур зөрүүтэй нийлүүлэгдсэн байдал
Зураг 6	Оффисын барилгын одоогийн байдал

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1	Хөрөнгө оруулалтын жагсаалт
Хавсралт 2	Соёл амралтын хүрээлэнгийн тоглоом, эд хөрөнгийн жагсаалт

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Аудитын төлөвлөгөө”-г үндэслэн “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

“Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр гүйцэтгэлээ. Үүнд:

- “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх,
- “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүнд тавих хяналт үр нөлөөтэй байгаа эсэх

Хамрах хүрээ:

“Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны мэдээлэл, санхүүгийн тайлан, тоон мэдээ болон Даланзадгад сумын ИТХ, ЗДТГ-аас ирүүлсэн судалгаа нотлох баримт, бодит байдалд хийсэн зураг авалт, хяналтын тооллогод үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 3000-3100, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан холбогдох баримт материалд үндэслэж, тулган баталгаажуулах, албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудсын дагуу аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж, санал боловсруулав.

Хүндрэл, бэрхшээл

Цар тахлын улмаас хамрагдагч байгууллагын удирдлага, албан тушаалтантай ярилцлага, уулзалт хийх боломж хязгаарлагдмал байлаа.

**Аудитад
ашигласан
шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

**Аудит
хийсэн
багийн
бүрэлдэхүүн**


Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр хянан удирдаж, аудитын менежер Т. Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитын багийг аудитор Ю.Энхтуяа ахлан, аудитор Э.Жаргал, Т.Хишигбат нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Бизнес төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан байна

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “ж”¹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4² дэх заалтуудыг үндэслэн Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 12 сарын 24-ны өдрийн 107 дугаар тогтоолоор “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ыг байгуулан дүрэм, орон тоог баталсан байна.

Дүрслэл №1. Дүрмийг шинэчлэн баталсан байдал:



1.2. Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 107 дугаар тогтоолд “тус газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь иргэдэд үйлчлэх, тэдний хэрэгцээ шаардлагыг хангасан, ая тухтай орчин бүрдүүлж, түргэн шуурхай, соёлтой, чанарын өндөр түвшинд төвлөрсөн цэгээс хүртээмжтэй хүргэхэд оршино” гэж заасан байна.

1.3. Даланзадгад сумын ИТХ-ын 2015 оны 76, 2017 оны 214 дүгээр тогтоолоор дүрмийг шинэчлэн баталсан боловч зорилт, зорилгын талаар тодорхой заагаагүй байна.


¹ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах

² Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ

1.4. Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 сарын 10-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор баталсан дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу нийтийн халуун ус, ахуй үйлчилгээний төвийн талбайн түрээс, соёл амралтын хүрээлэн зэрэг үндсэн 3 үйл ажиллагааг явуулж байна.

1.5. Соёл амралтын хүрээлэнгийн үйл ажиллагаа явуулахдаа Даланзадгад сумын ЗДТГ-т бүртгэлтэй эд хөрөнгийг ашигладаг боловч гэрээ байгуулаагүй байна.

Дүрслэл №2 Үндсэн үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлтүүд




Эх сурвалж: Даланзадгад сумын ИТХ-н Тэргүүлэгчдийн тогтоол

1.6. Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор бүтэц орон тоог 33 хүний бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн баталсан байна.

1.7. Үйл ажиллагааны үр дүн, орлогоос хамаарч батлагдсан орон тоогоор ажиллах боломжгүй байна.

Дүрслэл №3 Бүтэц орон тооны өөрчлөлтүүд:



Эх сурвалж: Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол

1.8. Нийтийн халуун ус нь 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй, ахуй үйлчилгээний төвийн барилга засвартай учир түрээслэгчдийг гаргасан, ковидийн нөхцөл байдал, улирлын чанартай үйл ажиллагаа зэргээс шалтгаалан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

1.9. Цаашид олон нийтийн хэрэгцээ шаардлага, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт хангасан, тав тухтай орчинд түргэн шуурхай, тогтвортой, үр ашигтай үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөлийг тусгасан ойрын болон хэтийн төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулан, мөрдөж ажиллах шаардлагатай байна.


Санхүүгийн зохистой байдал алдагдаж өр, авлага үүссэн байна

1.10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1 ³ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.11. Соёл амралтын хүрээлэн, нийтийн халуун усны газар нь сүүлийн 2-3 жилд тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй учир санхүүгийн алдагдалд орж цаашид үйл ажиллагаа явуулахад эрсдэл үүссэн байна.

График №1 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:

/мян.төг/



Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн тайлан

1.12. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа нь орлого тасрах, ажилчид тогтвортой ажиллахгүй байх үндсэн шалтгаан болж байна.


1.13. Санхүүгийн тайлангаар 2020 оны жилийн эцсийн байдлаар 2,957.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

³Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”

21 дүгээр зүйлийн 21.1 “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”

График №2 Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал:

/мян.төг/




Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн тайлан

1.14. Энэ нь Даланзадгад сумын нийтлэг үйлчилгээний 25 ажилчны цалин хөлс болон бусад зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

1.15. Өнгөрөгч 2020 онд гарсан зардлын 71 хувийг цалин хөлс, нийгмийн даатгал, 19 хувийг хангамжийн материал, 7 хувийг бусад зардал, 2.2 хувийг байр ашиглалтын зардал, 0.8 хувийг албан томилолт, хоолны зардал эзэлж байна.

График №03 2020 оны зардлыг мөнгөн дүнгээр харуулбал:

/мян.төг/



Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан

Хүснэгт № 1 2018-2020 онуудын нийт зардлын эдийн засгийн ангилал: /мян. төг/

Эдийн засгийн ангилал	2018 он	2019 он	2020 он
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	108,429.4	107,057.7	321,039.4
Байр ашиглалтын зардал	15,331.2	14,542.1	11,305.2
Хангамжийн материал	21,049.5	30,839.4	85,887.5
Хоолны зардал	-	-	3,486.4
Албан томилолтын зардал	-	-	2,500.0
Бусад зардал	10,528.7	20,914.7	29,934.4
Нийт зардал	155,338.8	173,353.9	454,152.9

/Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн тайлан/

1.16. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁴ дахь заалтыг хэрэгжүүлээгүй 1,549.7 мянган төгрөгийн өглөг, 9,920.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

1.17. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас жил бүр аудит хийж албан шаардлага, зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл №4 Санхүүгийн тайланд хийсэн 2018-2020 оны аудитын дүгнэлтүүд:



1.18. Насжилт өндөртэй 3,346.7 мянган төгрөгийн авлага байгаа нь нийт авлагын 33.7% хувийг эзэлж байна.

⁴Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”

Хүснэгт №2 Авлагын судалгаа:

/мян.төг/

№	Авлагын нэр төрөл	Үүссэн огноо	Мөнгөн дүн
1	Хувь хүнээс авах түрээсийн авлага	2017 он	1,230.0
2	Хувь хүнээс авах цалингийн авлага	2019 он	2,116.7
		2020 он	573.6
3	Хувь хүнээс авах бусад авлага	2020 он	6,000.0
	Нийт авлагын дүн		9,920.3

Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн тайлан

1.19. Тоглоомыг засварлах, сэлбэг хэрэгсэл худалдан авахаар 2020 онд 2 иргэнд 6,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч гүйцэтгэгч тал бараа материалыг одоог хүртэл нийлүүлээгүй байна.

1.20. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.4⁵, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

1.21. Иймд байгууллагыг хохиролгүй болгох талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын захиралд хүргүүлээ.

1.22. Мөн илүү олгосон цалин болон түрээсийн төлбөрийн 3,920.3 мянган төгрөгийн авлагатай байна.

1.23. Үүссэн өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажил зохион байгуулаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.


1.24. Орлого бүрдээгүйгээс шалтгаалсан 1,549.7 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

⁵ "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;

⁶ "Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ

График №04 Өглөгийн судалгаа:

/мян.төг/



Эх сурвалж: “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн тайлан

1.25. Цаашид санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ХАНГАГДААГҮЙ БАЙНА

Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ашиглалт хангалтгүй байна

2.1. Нийтийн халуун усны барилга нь 2016 онд ашиглалтад орсон ба үйлчлүүлэгч цөөн, алдагдалтай ажилладаг гэсэн шалтгаанаар 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

2.2. Байгууллагыг алдагдалгүй ажиллуулах үүднээс нийтийн халуун усны газрыг тухайн үйлчилгээгээр мэргэшсэн өөр байгууллагад шилжүүлэх, хувьчлах, түрээслэх зэрэг шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль, дүрмийн хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.3. Ахуй үйлчилгээний төвд 32 түрээслэгч үйл ажиллагаа явуулдаг ба барилгад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдэж байна.

2.4. Энэ оны 6 дугаар сарын байдлаар 930,065.6 мянган төгрөгийн 18 нэр төрлийн 89 ширхэг тоглоом, тоног төхөөрөмж эвдэрч ашиглах боломжгүй болсон байна.

2.5. Зарим өндөр өртөгтэй тоглоомыг сэлбэж засварлан ашиглах, ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 ⁷ дахь заалтын дагуу актлах шаардлагатай байна.

Тоглоом, тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүй ашигласан байна

2.6. Ашиглагдаж байгаа тоглоомуудад ашиглахыг зөвшөөрсөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт, зөвшөөрөл гаргуулаагүй байна.

2.7. Зөвхөн тоглоомын тоног төхөөрөмжүүдийг дагалдаж ирсэн “Тус бүтээгдэхүүн нь чанарын шаардлага хангасан тул үйлдвэрээс гаргахыг зөвшөөрөв” гэсэн утга бүхий үйлдвэрлэгчийн “Бүтээгдэхүүний баталгаажуулалтын хуудас” байна.

2.8. Алсыг харагчийн суурийн бат бэхэд 2017 оны 7 дугаар сарын 29-ны өдөр барилгын техник хяналт, зөвлөх үйлчилгээний “Эрдэм түм” ХХК үзлэг хийж “... зураг төсөлд заасан С25 ангийн бетоны шаардлагыг бат бэхийн хувьд хангана гэж үзэж байна” гэж дүгнэжээ.

2.9. МХГ, ОБГ-т “барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тоглоомуудыг хүлээн авч байгаа тул мэргэжлийн дүгнэлт гаргаж хамтран ажиллана уу” гэсэн албан бичгийг 2018 оны 5 дугаар сар, 2019 оны 4 дүгээр сард хүргүүлсэн байна.

2.10. МХГ-аас ирүүлсэн 2019 оны 5 дугаар сарын 176 дугаартай албан бичигт:

- Тоглоомуудын техникийн паспорт, баримт бичиг нь хятад хэл дээр, техник ашиглалтын монгол хэл дээр орчуулсан дүрэмгүй, туршилт тохируулга хийсэн актгүй,
- Хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй болохыг тогтоосон холбогдох мэргэжлийн байгууллагын албан ёсны дүгнэлтгүй байх тул .. “Үйлдвэрлэл үйлчилгээний машин механизм, тоног төхөөрөмжид гэрчилгээ олгох журам”-ын дагуу дүгнэлт гаргаж, гэрчилгээ олгох боломжгүй байна” гэжээ.

2.11. МХГ-ын улсын байцаагчид галын аюулгүй байдал, цахилгааны аюулгүй байдал, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, алсыг харагчийн салхины хурд хэмжигч зэрэгт 2019 оны 5 дугаар сарын 31-ы өдөр хяналт хийж, зөвлөмж өгсөн байна.

⁷ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах”

2.12. “ӨБЦТС” ТӨХК-аас ирүүлсэн 2020 оны 09 сарын 04-ы өдрийн 02/439 дугаар албан бичигт “ ... цахилгаан дамжуулах агаарын шугам ... аваарын байдлаар тасрахад алсыг харагч төхөөрөмж дээр 2 цагийн хугацаанд 7 хүн гацаж онцгой эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн. ... дахин тасралт гарах эрсдэлтэй тул ... ерөнхий шит хайрцагт сэлгэн залгагч автомат байршуулах арга хэмжээг авах шаардлагатай ...” гэжээ.

2.13. Цахилгааны засвар, үйлчилгээ хийлгэсэн гэх боловч одоог хүртэл ерөнхий шитэнд сэлгэн залгагч автомат байршуулаагүй байна.

2.14. Монгол Улсад “Тоглоомын төхөөрөмж, тоглоомын хөсгийн аюулгүй байдал” 3 цуврал стандарт батлагдсан байна. Үүнд:

- MNS EN 13814-1:2020 дизайн үйлдвэрлэл,
- MNS EN 13814-2:2020 - үйл ажиллагаа засвар ашиглалт,
- MNS EN 13814-3:2020- Зураг төсөл боловсруулах, үйлдвэрлэх, ажиллуулах, ашиглах явцад үзлэг хийхэд тавих шаардлага.

2.15. Эдгээр стандартууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-нд батлагдаж, 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн ба “ ... тойрог зам, дүүжин, завь, алсыг харагч, галзуу хулгана, гулсуур, тоглоомын байшин болон агаарт өнгө өнгийн дүрс үзүүлдэг төхөөрөмж зэрэг хөдөлгөөнт, түр зуур эсвэл байнга суурилуулсан машин, тоног төхөөрөмж, байгууламж ... энд дурдаагүй ижил төстэй бүтэц, зорчигч зөөвөрлөх зориулалтын төхөөрөмжид энэхүү баримт бичгийг ашиглана” гэж заажээ.

2.16. Тоглоомын төхөөрөмжийн ашиглалтын байдалд мэргэжлийн байгууллагаар хяналт гүйцэтгүүлж, дүгнэлт гарсны дараа ашиглах, дотоод хяналтыг сайжруулах, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байна.

Хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт хийгдээгүй байна

2.17. Орон нутгийн өмчийн газраас эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар ажил зохион байгуулаагүй байна.

2.18. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 66 дугаар зүйлийн 66.1⁸ дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

⁸ 11 дүгээр зүйл. ”/төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах;

2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

2.19. Даланзадгад сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 сарын 28-ы өдрийн хурлаар тус газрын үйл ажиллагаатай танилцаж үүрэг чиглэл өгсөн байна.

2.20. Гэвч орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийгээгүй байна.

2.21. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.1⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2.22. Цаашид орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих мэргэжлийн хяналт, шалгалтыг зохион байгуулж, ашиглалтын байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Зарим тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байна

2.23. Соёл амралтын хүрээлэнд байрлах 8,150,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Даланзадгад сумын ЗДТГ-ын даргаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гүйцэтгэгч “Говь эрдэнэс групп” ХХК-аас хүлээн авч, Даланзадгад сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

2.24. Эдгээрээс 2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 905,998.3 мянган төгрөгийн эд хөрөнгө ашиглагдах боломжгүй байна.

Үүнд:

- 190,098.3 мянган төгрөгийн үнэ бүхий услалтын систем,
- 12,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий үлэг гүрвэл,
- 650,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий эргэдэг гулсуур,
- 30,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 10ш мөргөлддөг машин,
- 13,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3ш завь,
- 5,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий сагсны шийт,
- 2,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 10ш дүнзэн сандал

66 дугаар зүйл. Хяналт шалгалтын тогтолцоо 1.Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ.

⁹ 77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.

2. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

1/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;

2.25. Энэ нь тоног төхөөрөмжийг техникийн даалгавартай тулгаж нягтлалгүй хүлээж авсан, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалсан байна.

Хүснэгт №3 Соёл амралтын хүрээлэнгийн хөрөнгийн жагсаалт: /мян.төг/

№	Хөрөнгийн төрөл	Нийт үнэ
1	Барилга байгууламж	3,175,312.3
2	Тоглоом	2,781,200.0
3	Зам талбай	767,018.0
4	Шугам сүлжээ	551,476.7
5	Ногоон байгууламж	356,960.0
6	Үлэг гүрвэл	326,000.0
7	Гэрэлтүүлэг	145,233.0
8	Бусад эд хөрөнгө	46,800.0
	Нийт	8,150,000.0

Эх сурвалж: Даланзадгад сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн баримт

2.26. Ашиглалтын шаардлага хангахгүй тоглоом, тоног төхөөрөмж хүлээн авч, түүний засвар үйлчилгээнд зориулж 2019-2020 онд 60,390.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан нь байгууллагыг алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.


2.27. Иймд тайлагналын дараах үе шатанд Соёл амралтын хүрээлэнг барьж байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагааны баримтыг шалгах шаардлага үүсч байна.

2.28. Мөн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2019 онд хүлээн авсан 21,809.4 мянган төгрөгийн картын систем, 1,700.0 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер ашиглагдахгүй байна.

2.29. Соёл амралтын хүрээлэнд орон нутгийн төсвөөр 2018 онд 50,000.0, 2019 онд 102,700.0, 2020 онд 213,700.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ.

Дүрслэл № 5 САХ-д 2018 – 2020 онуудад хийгдсэн хөрөнгө оруулалт:

/мян төг/



2.30. “Ургац капитал” ХХК-ий нийлүүлсэн 97,582.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй 17 нэр төрлийн тоглоомоос 10,362.8 мянган төгрөгийн 4 ширхэг завьны бүрэн бүтэн байдал алдагдсан, 7,012.5 мянган төгрөгийн 2 ширхэг уралдааны автомат машин шатсан, ашиглах боломжгүй байна.

2.31. Энэ нь Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1¹⁰ дахь хэсгийг зөрчсөн байна. Иймд нийлүүлэгч компаниар байгууллагыг хохиролгүй болгох талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг Даланзадгад сумын Засаг даргад хүргүүллээ.

Хөрөнгө оруулалт үр ашиггүй байна

2.32. “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-т 2018-2020 онуудад хийгдсэн 8 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шинжилгээ хийхэд 1 компани материалаа ирүүлсэн, эсвэл нэг ч компани материал ирүүлээгүй шалтгаанаар шууд гэрээ байгуулсан байна.

2.33. Энэ нь тендерийн зар олон нийтэд хүрээгүйтэй холбоотой байна.

¹⁰ Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ

Хүснэгт №4 Худалдан авах ажиллагаа:

/мян.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Огноо	Тендер шалгаруулалтын арга	Оролцсон компани	Гэрээ байгуулсан компани
1	САХ-ийн тохижилт, засвар үйлчилгээний ажил	2018	Харьцуулалт	-	Баян арвижих ХХК
2	ДП-110 цахилгааны дэд өртөөг солих ажил	2019	Харьцуулалт	-	ЖМ барса ХХК
3	САХ-ийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	2019	Харьцуулалт	-	Мичид халиун ХХК
4	САХ-д гүн өрмийн худаг гаргах	2019	Харьцуулалт	Болор ус ХХК	Ноён хөөвөрийн говь ХХК
5	САХ-д ухаалаг картын үйлчилгээ нэвтрүүлэх	2019	Харьцуулалт	Дүйнхэр тэргүүн ХХК	Дүйнхэр тэргүүн ХХК
6	САХ-ийн гадна, дотор талыг хэсэгчилсэн засварлах, стандартын тамхины цэг байгуулах БАГЦ-1	2020	НТШ	Даянбайгаль ХХК	Даянбайгаль ХХК
7	САХ-ийн засвар, тамхины цэг байгуулах БАГЦ-2	2020	НТШ	Даянбайгаль ХХК	Даянбайгаль ХХК
8	Хүүхдийн тоглоом нэмэгдүүлэх ажил	2020	НТШ	Ургац капитал ХХК	Ургац капитал

Эх сурвалж: Даланзадгад сумын ЗДТГ-ын худалдан авах ажиллагааны баримт

2.34. Аудитаар дээрх хөрөнгө оруулалтуудтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

➤ Соёл амралтын хүрээлэнд гүн өрмийн худаг гаргах /2019 он/

Гүйцэтгэгч: Ноён хөөвөрийн говь ХХК

Гэрээний дүн: 40,000.0 мянган төгрөг

Зөрчлийн утга: Худгийн усны ундарга муу учир эргэн тойрны мод, ногоон байгууламжийг услахад хүрэлцэхгүй байна.

Зураг №1 Гүн өрмийн худаг гаргасан байдал



- Соёл амралтын хүрээлэнд гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажил /2019 он/

Гүйцэтгэгч: Мичид халиун ХХК

Гэрээний дүн: 23,000.0 мянган төгрөг

Зөрчлийн утга: Хүний нөөц дутагдалтайгаас хүлээн авснаас хойш ашиглагдаагүй байна.

Зураг №2 Гал тогооны тоног төхөөрөмж ашиглагдахгүй байгаа байдал:



- Соёл амралтын хүрээлэнгийн гадна, дотор талыг хэсэгчилсэн засварлах, стандартын тамхины цэг байгуулах ажил багц-2 /2020 он/

Гүйцэтгэгч: Даян байгаль ХХК

Гэрээний дүн: 24,001.3 мянган төгрөг

Зөрчлийн утга: Барилгын битүүмж муу, тоос орсон, дээврээс борооны ус нэвтэрсэн байна.

Зураг №3 Тамхины цэгийн дотор шороо орсон, дээврээс ус гоожсон байдал



- Хүүхдийн тоглоом нэмэгдүүлэх ажил /2020 он/

Гүйцэтгэгч: Ургац капитал ХХК

Гэрээний дүн: 97,582.6 мянган төгрөг

Зөрчлийн утга: Гэрээт ажлыг хүлээж авахад зарим тоглоом дутуу байсан, хүлээн авахад чанаргүй, хуучин, эвдэрсэн байснаас зарим тоглоом ашиглах боломжгүй байна.

Даланзадгад сумын ЗДТГ-аас гаргасан ажлын даалгавар

“Ургац капитал” ХХК-ны нийлүүлсэн тоглоомын бодит байдал

Зураг №4 Усан завь зөрүүтэй нийлүүлэгдсэн байдал / 4 хүн суух зориулалттай/



Зураг №5 Гулсуур зөрүүтэй нийлүүлэгдсэн байдал /Гадаа талбайн зориулалттай гулсуур/



2.35. Соёл амралтын хүрээлэнгийн гал тогоо, оффисын барилгын цонх дагаж борооны ус урссан, шороо тоос нэвтэрсэн, халаалт байхгүй зэргээс барилгын дотор үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгаа тул дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбон засварлаж ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна.

Зураг-6 Цонхны завсраар ус нэвтэрч хананы дотор, гадна будаг хуурсан байдал



2.36. “Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ нь үндсэн бүтэц, орон тоогоор ажиллаж чадахгүй байгаагаас соёл амралтын хүрээлэнгийн ногоон байгууламжийг арчлах, ургуулах, динозаврыг нөхөн сэргээх, тоглоом, тоног төхөөрөмжийн өдөр тутмын арчилгаа, үйлчилгээг хийх боломжгүй нөхцөл үүссэн байна.

2.37. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж эрүүл аюулгүй орчинд үйлчилгээ үзүүлэх шаардлагын үүднээс дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Хувилбар-1:

Соёл амралтын хүрээлэн нь агаарын бохирдлыг бууруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, олон нийтийн амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл эко орчныг бүрдүүлэх, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тул ОНТҮГ болгон өөрчлөн байгуулж, ажилчдын цалинг орон нутгийн төсөвт суулган батлуулж, ажиллуулах, /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйл¹¹/

Хувилбар-2:

Байгууллагын удирдах үйл ажиллагааг (менежмент) удирдлагын өндөр мэргэшил, дадлагатай, үйлдвэрлэл, үйлчилгээг үр ашигтай зохион байгуулах ур чадвартай, хувийн өмчит хуулийн этгээд, хувь хүнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйл¹²/

Хувилбар-3:

Соёл амралтын хүрээлэн нь нийт 10 га газар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 57% нь буюу 5.7 га газарт ногоон байгууламж байна. Иймд Даланзадгад сумын ногоон байгууламжийг хариуцдаг Даланзадгад сумын Захирагчийн ажлын албанд удирдлагыг шилжүүлж, холбогдох хууль, дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллуулах,

¹¹ Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал

1.Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна:

2.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

3.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

¹² Удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах

1. Төрийн өмчит хуулийн этгээдийг удирдах үйл ажиллагааг / менежмент/ удирдлагын өндөр мэргэшил, дадлагатай, үйлдвэрлэлийг үр ашигтай зохион байгуулах ур чадвартай, хувийн өмчит хуулийн этгээд, хувь хүнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2. Менежментийн гэрээгээр ажиллах этгээд нь гэрээнд заасан бол өөрийн багийг бүрдүүлж болно.

3. Менежментийн гэрээг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр хуульд өөрөөр заагаагүй бол 3 хүртэл жилийн хугацаагаар бичгээр байгуулна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.
Үүнд:

- Бизнес төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан байна.
- Даланзадгад сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тоног төхөөрөмжийг ашиглахдаа хөрөнгө эзэмших, ашиглах гэрээ хэлцэл байгуулаагүй байна.
- Санхүүгийн зохистой байдал алдагдаж өр, авлага үүссэн байна.
- Тоглоомын төхөөрөмж нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, туршилт тохируулга хийгдээгүй учир аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй байна.
- Эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт муу байна.
- Тоглоомын төхөөрөмжийг хүлээж авахдаа техникийн даалгавар, тендерийн материалтай тулгаж нягтлаагүйгээс чанаргүй, хуучин тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.
- Тоглоом, тоног төхөөрөмжийг баталгаат хугацаанд засварлуулах ажил зохион байгуулаагүй байна.
- Тоног төхөөрөмж хүлээж авахдаа бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгаагүйгээс зарим өндөр үнэтэй тоглоомын төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй болж, орон нутгийн өмчийн эд хөрөнгө үнэгүйдсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Даланзадгад сумын ИТХ-ын дарга Т.Мэндээ, Засаг дарга Х.Батболд нарт:

- Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, олон нийтэд эрүүл, аюулгүй орчинд үйлчилгээ үзүүлэх үүднээс удирдлагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг өөрчлөн сайжруулах арга хэмжээ авах,
- Холбогдох хууль, дүрмийн дагуу шийдвэр гаргаж, үндсэн хөрөнгийг гэрээний дагуу эзэмшүүлж ашиглуулах, шаардлагатай бол шилжүүлэх,
- Эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хийх хяналт, шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагад үндэслэн, үр ашигтай төлөвлөж, зөв зохион байгуулах,
- Тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа иж бүрдэл дутуу, техникийн туршилт тохируулга хийгдээгүй бол санхүүжилт олгохгүй байх

“Даланзадгад говийн ирээдүй” ОНӨААТҮГ-н захирал Э.Мөнхцэцэгт:

- Байгууллагын бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах,
- Төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх,
- Тоглоомын төхөөрөмж, тоглоомын хөсгийн аюулгүй байдал- цуврал стандарт MNS EN 13814-2:2020, MNS EN 13814-3 : 2020 стандартыг хэрэгжүүлэн мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах арга хэмжээг зохион байгуулж, холбогдох норм , дүрэм, стандартыг мөрдөж ажиллах,
- Тоглоомын төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа холбогдох хууль, дүрэм, журмыг баримталж ажиллах,

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/35

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Даланзадгад говийн ирээдүй ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Б.Бадраа), Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Т.Мэндээ), Даланзадгад сумын Засаг дарга (Х.Батболд), Даланзадгад говийн ирээдүй ОНӨААТҮГ (Э.Мөнхцэцэг) нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Даланзадгад говийн ирээдүй ОНӨААТҮГ-т газарт зөвлөсүгэй.

4. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын баг (Ю.Энхтуяа)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын Менежер (Т.Хонгорзул)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ЦЭРЭНБАЯР

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2021\А-35.Docx

016010051

Хавсралт-1 Хөрөнгө оруулалтын жагсаалт:

/мян.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Он	Санхүүжилтийн эх үүсвэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн
1.	САХ-ийн тохижилт, засвар үйлчилгээний ажил	2018	ОНТХО	Баян арвижих ХХК	50,000.0
2.	ТП-110 цахилгааны дэд өртөөг солих ажил	2019	ОНТХО	ЖМ барса ХХК	17,860.0
3.	САХ-ийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	2019	ОНТХО	Мичид халиун ХХК	23,000.0
4.	САХ-д гүн өрмийн худаг гаргах ажил	2019	ОНТХО	Ноён хөөврийн говь ХХК	40,000.0
5.	САХ-д ухаалаг картын үйлчилгээ нэвтрүүлэх	2019	ОНТХО	Дүйнхэр тэргүүн ХХК	21,809.4
6.	САХ-ийн гадна, дотор талыг хэсэгчлэн засварлах, стандартын тамхины цэг байгуулах БАГЦ-1	2020	ОНТХО	Даян байгаль ХХК	92,088.8
7.	САХ-ийн гадна, дотор талыг хэсэгчлэн засварлах, стандартын тамхины цэг байгуулах БАГЦ-2	2020	ОНТХО	Даян байгаль ХХК	24,001.3
8.	Хүүхдийн тоглоом нэмэгдүүлэх ажил	2020	ОНТХС	Ургац капитал ХХК	97,582.6
Нийт					366,342.1

/Эх сурвалж: Даланзадгад сумын ЗДТГ-ын худалдан авах ажиллагааны баримт/

Хавсралт-2 Соёл амралтын хүрээлэнгийн тоглоомын жагсаалт

/мян.төг/

№	Тоглоом, тоног төхөөрөмжийн нэр	Тоо шир хэг	Техникийн үзүүлэлт	өртөг		Үйлдвэрлэгдс эн он, сар	Үйлдвэрлэгчийн мэдээлэл	Ашиглалтын байдал
				нэгж	нийт			
1	Алсыг харагч	1	46м өндөр, 96 хүний, 8,5 мин/эргэлт	1,100,000.0	1,100,000.0	2017 оны 2 сар	БНХАУ-ын Шиань Багио хотын Шиань Жимми тоглоом, тоног төхөөрөмжийн үйлдвэр	
2	Огторгуйн пуужин	1	16-24 хүний , 12 м/с хурдтай, 15м*15м	550,000.0	550,000.0	2015 оны 5 сар	БНХАУ-ын Жөнжоу хотын Хэт эрин тоглоомын үйлдвэрт	
3	Мөргөлддөг машин	10	1-2 хүний суудалтай	3,000.0	30,000.0	2015 оны 5 сар	БНХАУ-ын Жөнжоу хотын Хэт эрин тоглоомын үйлдвэрт	Ашиглах боломжгүй болсон
4	Хөгжимт гулсуур	1	18-24 хүний суудалтай, 8м*20м	650,000.0	650,000.0	2016 оны 9 сар	БНХАУ-ын Жөнжоу хотын Хэт эрин тоглоомын үйлдвэрт	Ашиглах боломжгүй болсон
5	Галт тэрэг	1	16 хүний суудалтай, 6м	40,000.0	40,000.0	2015 оны 5 сар	БНХАУ-ын Жөнжоу хотын Хэт эрин тоглоомын үйлдвэрт	
6	Морин тойруулга	1	24-32 хүний суудалтай	390,000.0	390,000.0	2015 оны 5 сар	БНХАУ-ын Жөнжоу хотын Хэт эрин тоглоомын үйлдвэр	
7	Завь	3	том	4,500.0	13,500.0	2016 он	БНХАУ	Ашиглах боломжгүй болсон.
8	Завь	4	жижиг	500.0	2,000.0	2016 он	БНХАУ	
9	Сагсны шийт	1	хос	5,700.0	5,700.0	2016 он	БНХАУ	Ашиглах боломжгүй болсон
10	Үлэг гүрвэл	2	том	25,000.0	50,000.0	2016 он	БНХАУ	
11	Үлэг гүрвэл	7	дунд	12,000.0	84,000.0	2016 он	БНХАУ	1 ш үлэг гүрвэл эвдэрсэн
12	Үлэг гүрвэл	9	бусад	20,000.0	180,000.0	2016 он	БНХАУ	
13	Усалгааны систем	1	Иж бүрдэл	190,098.3	190,098.3	2017 он	БНХАУ	Ашиглах боломжгүй болсон.